

ИХЭРМӨРӨН-АУДИТ ХХК



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөвсгөл аймгийн Цагааннуур сумын ерөнхий боловсролын сургуулийн  
2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн  
аудитын хураангуй тайлан

Аудитын код: ХӨА-2024/188/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Мөрөн сум 2024 он</p>	<p>Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар Утас: 88883317 Цахим хаяг: <a href="mailto:erdenebaatara@audit.gov.mn">erdenebaatara@audit.gov.mn</a> Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр Утас: 99089114 Цахим хаяг: <a href="mailto:tegshdelgerb@audit.gov.mn">tegshdelgerb@audit.gov.mn</a> Аудитор: Г.Ичинхорлоо Утас: 88688168 Цахим хаяг: <a href="mailto:ichinkhorloog@audit.gov.mn">ichinkhorloog@audit.gov.mn</a> Ихэрмөрөн-Аудит ХХК-ийн захирал Б.Мядагмаа Утас: 99389208 Цахим хаяг: <a href="mailto:b_myadagmaa@yahoo.com">b_myadagmaa@yahoo.com</a> Аудитор Д.Оюундаваа Утас: 99382220 Цахим хаяг: <a href="mailto:oyundavaa@gmail.com">oyundavaa@gmail.com</a></p>
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,  
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120  
Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khuvsgul@audit.gov.mn  
Цахим хуудас: www.audit.mn

2024.02.26 № 01/180  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЦАГААННУУР  
СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН  
СУРГУУЛИЙН ЗАХИРЛЫН ҮҮРГИЙГ  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ  
Ч.ОЮУНБАДАМ ТАНАА

**Хараат бус аудиторын дүгнэлт**

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөвсгөл аймгийн Цагааннуур сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Цагааннуур сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 279,488.7 мянган төгрөгөөр өссөн байна.

**Аудитын гол асуудал**

Тайлант оны санхүүгийн тайланг Төсвийн тухай хуульд заасан цаглаварт хугацаанаас 25 хоног хоцроож ирүүлсэн зөрчилд хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлсэн.

**Бусад асуудлын хэсэг**

Цагааннуур сумын Ерөнхий боловсролын сургууль нь тайлант хугацаанд 7 зорилт бүхий 48 арга хэмжээ төлөвлөн 85.0 хувьтай биелүүлж ажилласан байна.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

5724040238

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



А.ЭРДЭНЭБААТАР

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>245,857,311.11</b>	<b>617,153,696.24</b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	<b>17,184,553.00</b>	<b>296,673,229.45</b>
<b>31200</b>	<b>Банканд байгаа бэлэн мөнгө</b>	<b>17,184,553.00</b>	<b>296,673,229.45</b>
<b>31210</b>	<b>Төгрөг</b>	<b>17,184,553.00</b>	<b>296,673,229.45</b>
31211	Төрийн сангийн харилцах	17,184,553.00	296,673,229.45
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	<b>7,733,562.00</b>	<b>12,503,478.98</b>
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	7,733,562.00	7,298,468.98
<b>33500</b>	<b>Бусад авлага</b>	<b>0</b>	<b>5,205,010.00</b>
33510	Байгууллагаас авах авлага	0	3,466,300.00
33520	Хувь хүмүүсээс авах авлага	0	1,738,710.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>220,939,196.11</b>	<b>307,976,987.81</b>
<b>35100</b>	<b>Түүхий эд материал</b>	<b>828,000.00</b>	<b>524,700.00</b>
35130	Эм боох материал	828,000.00	524,700.00
<b>35400</b>	<b>Хангамжийн материал</b>	<b>220,111,196.11</b>	<b>307,452,287.81</b>
35410	Бичиг хэргийн материал	3,615,400.00	2,677,400.00
35420	Аж ахуйн материал	93,901,197.72	94,506,197.72
35440	Түлш, шатах тослох материал	16,979,642.50	78,918,401.50
35450	Барилгын засварын материал	19,558,685.50	16,855,500.00
35460	Хүнсний материал	32,343,300.00	55,486,820.00
35470	Бусад хангамжийн материал	53,712,970.39	59,007,968.59
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>2,896,499,325.74</b>	<b>2,828,946,423.40</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>2,896,499,325.74</b>	<b>2,828,946,423.40</b>
<b>39200</b>	<b>Биет хөрөнгө</b>	<b>2,765,385,875.82</b>	<b>2,698,104,723.56</b>
39201	Барилга, байгууламж, орон сууц	2,739,119,949.78	2,739,119,949.78
39202	Хуримтлагдсан элэгдэл	-304,710,671.56	-375,569,303.76
39203	Авто-тээврийн хэрэгсэл	36,700,310.00	36,700,310.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-19,542,008.42	-28,614,643.46
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	196,788,882.80	254,374,882.80
39206	Хуримтлагдсан элэгдэл	-40,687,918.45	-89,963,323.91
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	187,537,949.09	210,462,949.09
39208	Хуримтлагдсан элэгдэл	-76,878,621.94	-97,104,350.52
39214	Бусад үндсэн хөрөнгө	1,500,000.00	1,500,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-166,666.68	-333,333.36
39217	Ном	45,724,671.20	47,531,586.90
<b>39300</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	<b>131,113,449.92</b>	<b>130,841,699.84</b>
39301	Программ хангамж	1,087,000.00	1,087,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-271,750.08	-543,500.16
39303	Бусад биет бус хөрөнгө	130,298,200.00	130,298,200.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>3,142,356,636.85</b>	<b>3,446,100,119.64</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>895,903.71</b>	<b>25,384,680.60</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>895,903.71</b>	<b>25,384,680.60</b>
<b>41300</b>	<b>Өглөг</b>	<b>895,903.71</b>	<b>25,384,680.60</b>
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	0	16,395,834.20
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	272,103.71	4,995,346.40
<b>41360</b>	<b>Бусад өглөг</b>	<b>623,800.00</b>	<b>3,993,500.00</b>
41361	Байгууллагад төлөх өглөг	623,800.00	3,635,500.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	0	358,000.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>3,141,460,733.14</b>	<b>3,420,715,439.04</b>

<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>3,141,460,733.14</b>	<b>3,420,715,439.04</b>
51100	Засгийн газрын оруулсан капитал	614,871,262.10	614,871,262.10
511002	Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө	614,871,262.10	614,871,262.10
<b>51200</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>2,015,736,934.30</b>	<b>2,294,991,640.20</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	-1,126,088,927.84	2,015,736,934.30
51220	Тайлант үеийн үр дүн	3,141,825,862.14	279,254,705.90
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	510,852,536.74	510,852,536.74
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>3,142,356,636.85</b>	<b>3,446,100,119.64</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>1,479,302,931.80</b>	<b>1,970,575,163.90</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>87,824,231.80</b>	<b>42,342,363.90</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>87,825,231.80</b>	<b>42,342,363.90</b>
<b>120004</b>	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	<b>2,975,000.00</b>	<b>70,000.00</b>
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,975,000.00	70,000.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	2,960,814,720.81	40,296,915.70
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	84,850,231.80	1,975,448.20
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1,391,477,700.00</b>	<b>1,928,232,800.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>1,233,975,200.00</b>	<b>1,744,099,500.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,233,975,200.00	1,744,099,500.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>105,000.00</b>	<b>0</b>
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>157,397,500.00</b>	<b>184,133,300.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	157,397,500.00	184,133,300.00
<b>II</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>1,404,707,050.68</b>	<b>1,691,320,458.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,404,707,050.68</b>	<b>1,691,320,458.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,347,466,410.68</b>	<b>1,600,106,578.00</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>901,188,440.00</b>	<b>1,053,008,014.61</b>
210101	Үндсэн цалин	835,420,350.00	778,552,979.61
210102	Нэмэгдэл	4,326,460.00	214,785,070.00
210104	Урамшуулал	61,441,630.00	59,669,965.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>112,635,016.00</b>	<b>132,999,351.16</b>
210201	Тэтгэврийн даатгал	77,385,370.00	92,278,469.95
210202	Тэтгэмжийн даатгал	9,001,349.00	10,550,474.25
210203	ҮОМШӨ-ний даатгал	7,244,250.00	8,440,379.65
210204	Ажилгүйдлийн даатгал	1,723,938.00	1,975,454.48
210205	Эрүүл мэндийн даатгал	17,280,109.00	19,754,572.83
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>64,859,221.61</b>	<b>76,209,978.69</b>
210301	Гэрэл, цахилгаан	9,831,860.71	13,658,004.19
210302	Түлш, халаалт	54,057,360.90	59,356,274.50
210303	Цэвэр, бохир ус	970,000.00	3,195,700.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>113,027,650.00</b>	<b>117,858,625.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	0	1,617,700.00
210502	Хоол, хүнс	113,027,650.00	116,240,925.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>14,182,900.00</b>	<b>20,295,385.50</b>

210604	Урсгал засвар	14,182,900.00	20,295,385.50
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>7,542,000.00</b>	<b>4,860,000.00</b>
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	7,542,000.00	4,860,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>134,031,183.07</b>	<b>194,875,223.04</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	26,588,088.00	29,934,205.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	7,918,700.00	15,070,200.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	99,524,395.07	149,870,818.04
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>57,240,640.00</b>	<b>91,213,880.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>54,135,640.00</b>	<b>61,213,880.00</b>
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	54,135,640.00	50,553,680.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	0	10,660,200.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>105,000.00</b>	<b>0</b>
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	105,000.00	0
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>3,000,000.00</b>	<b>30,000,000.00</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,000,000.00	30,000,000.00
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)</b>	<b>74,595,881.12</b>	<b>279,251,705.90</b>
<b>VI</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)</b>	<b>74,595,881.12</b>	<b>279,254,705.90</b>

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>1,394,452,700.00</b>	<b>1,929,155,600.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>2,975,000.00</b>	<b>922,800.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>2,975,000.00</b>	<b>922,800.00</b>
<b>120004</b>	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	<b>2,975,000.00</b>	<b>922,800.00</b>
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0	852,800.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,975,000.00	70,000.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1,391,477,700.00</b>	<b>1,928,232,800.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>1,233,975,200.00</b>	<b>1,744,099,500.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,233,975,200.00	1,744,099,500.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>105,000.00</b>	<b>0</b>
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>157,397,500.00</b>	<b>184,133,300.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	157,397,500.00	184,133,300.00
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>1,342,059,147.00</b>	<b>1,607,645,923.55</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,342,059,147.00</b>	<b>1,607,645,923.55</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,285,240,147.00</b>	<b>1,502,662,523.55</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>914,875,900.00</b>	<b>1,037,915,793.80</b>
210101	Үндсэн цалин	700,636,012.55	763,460,761.26
210102	Нэмэгдэл	171,428,097.70	214,785,068.35
210103	Унаа хоолны хөнгөлөлт	0	0
210104	Урамшуулал	42,811,789.75	59,669,964.19
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>107,046,247.00</b>	<b>132,999,354.75</b>
210201	Тэтгэврийн даатгал	72,381,422.15	90,439,557.38
210202	Тэтгэмжийн даатгал	8,522,450.48	10,639,946.68
210203	ҮОМШӨ-ний даатгал	7,169,705.78	8,511,956.52

210204	Ажилгүйдлийн даатгал	1,725,813.47	2,127,987.42
210205	Эрүүл мэндийн даатгал	17,246,855.12	21,279,906.75
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>60,000,000.00</b>	<b>138,071,300.00</b>
210301	Гэрэл, цахилгаан	9,102,102.50	11,724,605.57
210302	Түлш, халаалт	49,897,897.50	123,500,535.83
210303	Цэвэр, бохир ус	1,000,000.00	2,846,158.60
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>120,293,800.00</b>	<b>122,322,425.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	0	0
210502	Хоол, хүнс	120,293,800.00	122,322,425.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>35,897,500.00</b>	<b>16,062,000.00</b>
210604	Урсгал засвар	35,897,500.00	16,062,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>7,542,000.00</b>	<b>9,179,100.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	0	852,800.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	7,542,000.00	8,326,300.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>39,584,700.00</b>	<b>46,112,550.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	27,859,200.00	33,623,050.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	11,725,500.00	12,489,500.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>56,819,000.00</b>	<b>104,983,400.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>53,714,000.00</b>	<b>74,983,400.00</b>
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	53,714,000.00	64,323,200.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	0	10,660,200.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>105,000.00</b>	<b>0</b>
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	105,000.00	0
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>3,000,000.00</b>	<b>30,000,000.00</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,000,000.00	30,000,000.00
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)</b>	<b>52,393,553.00</b>	<b>321,509,676.45</b>
<b>V</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)</b>	<b>35,209,000.00</b>	<b>42,021,000.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>35,209,000.00</b>	<b>42,021,000.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>35,209,000.00</b>	<b>42,021,000.00</b>
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	35,209,000.00	42,021,000.00
<b>VI</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)</b>	<b>-35,209,000.00</b>	<b>-42,021,000.00</b>
<b>VIII</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)</b>	<b>17,184,553.00</b>	<b>279,488,676.45</b>
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0	17,184,553.00
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	17,184,553.00	296,673,229.45

#### 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/ төгрөгөөр /

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
----------	---------------------------------	-----------------------	-------------------	--

<b>2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>614,871,262.10</b>	<b>510,852,536.74</b>	<b>2,015,736,934.30</b>	<b>3,141,460,733.14</b>
<b>2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл</b>	<b>614,871,262.10</b>	<b>510,852,536.74</b>	<b>2,015,736,934.30</b>	<b>3,141,460,733.14</b>
<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>614,871,262.10</b>	<b>510,852,536.74</b>	<b>2,015,736,934.30</b>	<b>3,141,460,733.14</b>
Тайлант үеийн үр дүн	0	0	279,254,705.90	279,254,705.90
<b>2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>614,871,262.10</b>	<b>510,852,536.74</b>	<b>2,294,991,640.20</b>	<b>3,420,715,439.04</b>

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

### Улсын төсвийн гүйцэтгэл

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	зөрүү	хувь
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>1,762,554,100.00</b>	<b>1,465,533,623.55</b>	297,020,476.45	83.1
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,762,554,100.00</b>	<b>1,465,533,623.55</b>	297,020,476.45	83.1
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,679,985,000.00</b>	<b>1,390,550,223.55</b>	289,434,776.45	82.8
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>1,274,257,500.00</b>	<b>1,037,915,793.80</b>	236,341,706.20	81.5
210101	Үндсэн цалин	879,887,200.00	763,460,761.26	116,426,438.74	86.8
210102	Нэмэгдэл	331,369,700.00	214,785,068.35	116,584,631.65	64.8
210104	Урамшуулал	63,000,600.00	59,669,964.19	3,330,635.81	94.7
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>159,282,500.00</b>	<b>132,999,354.75</b>	26,283,145.25	83.5
210201	Тэтгэврийн даатгал	108,312,000.00	90,439,557.38	17,872,442.62	83.5
210202	Тэтгэмжийн даатгал	12,742,700.00	10,639,946.68	2,102,753.32	83.5
210203	ҮОМШӨ-ний даатгал	10,194,100.00	8,511,956.52	1,682,143.48	83.5
210204	Ажилгүйдлийн даатгал	2,548,600.00	2,127,987.42	420,612.58	83.5
210205	Эрүүл мэндийн даатгал	25,485,100.00	21,279,906.75	4,205,193.25	83.5
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>142,817,500.00</b>	<b>122,322,425.00</b>	20,495,075.00	85.6
210502	Хоол, хүнс	142,817,500.00	122,322,425.00	20,495,075.00	85.6
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>9,526,300.00</b>	<b>9,179,100.00</b>	347,200.00	96.4
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,200,000.00	852,800.00	347,200.00	71.1
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	8,326,300.00	8,326,300.00	0.00	100.0
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>94,101,200.00</b>	<b>88,133,550.00</b>	5,967,650.00	93.7
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	81,611,700.00	75,644,050.00	5,967,650.00	92.7
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	12,489,500.00	12,489,500.00	0.00	100.0
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>82,569,100.00</b>	<b>74,983,400.00</b>	7,585,700.00	90.8
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>82,569,100.00</b>	<b>74,983,400.00</b>	7,585,700.00	90.8
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	71,744,900.00	64,323,200.00	7,421,700.00	89.7
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	10,824,200.00	10,660,200.00	164,000.00	98.5
<b>III</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>1,762,554,100.00</b>	<b>1,745,022,300.00</b>	17,531,800.00	99.0
<b>31</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>1,744,099,500.00</b>	<b>1,744,099,500.00</b>	0.00	100.0
310001	Улсын төсвөөс санхүүжих	1,744,099,500.00	1,744,099,500.00	0.00	100.0

<b>35</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	<b>18,454,600.00</b>	<b>922,800.00</b>	17,531,800.00	5.0
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,200,000.00	852,800.00	347,200.00	71.1
350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	70,000.00	70,000.00	0.00	100.0
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	17,184,600.00	0	17,184,600.00	0.0
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0	17,184,553.00	-17,184,553.00	
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0	296,673,229.45	-	296,673,229.45

**Орон нутгийн төсвийн гүйцэтгэл**

Данс	Үзүүлэлт	төлөвлөгөө	Гүйцэтгэл	/төгрөгөөр/	
				Дүн	Хувь
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-	-	-
2	I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	184,133,300.00	154,133,300.00	30,000,000.00	83.7
21	УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	184,133,300.00	154,133,300.00	30,000,000.00	83.7
210	Бараа, үйлчилгээний зардал	184,133,300.00	154,133,300.00	30,000,000.00	83.7
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	138,071,300.00	138,071,300.00	-	100.0
210301	Гэрэл цахилгаан	11,800,000.00	11,724,605.57	75,394.43	99.4
210302	Түлш, халаалт	123,271,300.00	123,500,535.83	-229,235.83	100.2
210303	Цэвэр, бохир ус	3,000,000.00	2,846,158.60	153,841.40	94.9
2106	Эд хогшил худалдан авах	46,062,000.00	16,062,000.00	30,000,000.00	34.9
210604	Урсгал засвар	46,062,000.00	16,062,000.00	30,000,000.00	34.9
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	184,133,300.00	154,133,300.00	30,000,000.00	83.7
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	184,133,300.00	154,133,300.00	30,000,000.00	83.7
132001	Орон нутгийн төсвөөс	184,133,300.00	154,133,300.00	30,000,000.00	83.7
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-	-	-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-	-	-

**3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ**

Аудитаар нийт 1,026,317.5 мянган төгрөгийн мянган төгрөгийн алдаа зөрчил<sup>1</sup> илэрч, 8,000.0 мянган төгрөгийн 1 акт, хариуцлага тооцох 1 албан шаардлага, нийцлийн аудитаар шилэн дансны мэдээлэлтэй холбоотой 1,012,515.6 мянган төгрөгийн 1 зөвлөмж, санхүүгийн тайлангийн аудитаар 5,801.9 мянган төгрөгийн зөрчилд 4 зөвлөмж өглөө.

Аудитаар нягтлан бодох бүртгэлтэй холбоотой залруулгын алдаа илрээгүй болно.

Санхүүгийн тайлангийн аудитар илрүүлсэн 13,801.9 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа болон зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 8,673.3 мянган төгрөгөөр бага тул Өөрчлөлтгүй дүгнэлт өглөө

**1.1 Акт**

Багшийн хөгжлийг тасралтгүй хөгжлийг дэмжих болон байгууллагын гүйцэтгэлийн урамшууллын хөтөлбөр арга хэмжээний зардлаас батлагдсан төсвийн хүрээнд зардал гаргахдаа мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлж, багш, ажилтны мэргэжлийн хөгжлийг хангах,

<sup>1</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

зөвлөн туслах чиг үүрэгтэй, аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газрын арга зүйн хэлтсийн дарга Я.Дүүрэнбилэгтэй гэрээ байгуулан, сургалт хийлгэж төсвөөс 8,000.0 төгрөгийн төлбөр төлсөн байгаа нь Боловсролын ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.5-д “Аймаг, нийслэлийн боловсролын газар, дүүргийн боловсролын хэлтэс харьяа нутаг дэвсгэртээ дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ: өмчийн хэлбэр үл харгалзан бүх түвшний боловсролын сургалтын байгууллагад мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх, багш, ажилтны мэргэжлийн хөгжлийг хангах, зөвлөн туслах, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.3-т “төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах,” заалт, нийцсэн бөгөөд зохистой батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

### **3.2 Албан шаардлага**

Цагааннуур сумын ерөнхий боловсролын сургуулийн захирал, нягтлан бодогч нар нь 2023 оны санхүүгийн тайланг төсвийн тухай хуульд заасан цаглабарт хугацааг 25 хоног хоцроож 2024 оны 02 сарын 19-ны өдөр Ихэрмөрөн-аудит ХХК-д ирүүлсэн байгаа тул төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1 “төсвийн шууд захирагч улирлын төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг дараа улирлын эхний сарын 15-ны дотор гаргаж харьяалагдах дээд шатны төсвийн захирагчид, жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг дараа оны 01 дүгээр сарын 25-ны дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлж, аудит хийсэн санхүүгийн тайланг 02 дугаар сарын 25-ны дотор харьяалагдах дээд шатны төсвийн захирагчид хүргүүлэх” гэсэн заалтыг зөрчсөн тул нягтлан бодогч, захирал нарт сахилгын шийтгэл оногдуулах албан шаардлага бичигдлээ.

### **3.3 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### **1. Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой асуудал**

##### Илрүүлэлт:

Тус сургуулийн үндсэн хөрөнгөнд элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 93 нэр төрлийн 62,720.6 мянган төгрөгийн хөрөнгө бүртгэлтэй байгаа нь УСНББОУС-17 “Үндсэн хөрөнгө”-ийн параграф 67, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3 “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах,” заалт болон ТӨБЗГ-ын 2019 оны 271 дүгээр тогтоолын 7 дугаар бүлгийн 7.1 заалттай тус тус нийцээгүй, “үнэлгээ ба хуваарилалт” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

##### Өгсөн зөвлөмж:

Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг ОНӨГ-т хүргүүлэн шийдвэрлүүлж, үр дүнг нягтлан бодох бүртгэлд тусгах

#### **2. Төсвийн гүйцэтгэлтэй холбоотой асуудал**

##### Илрүүлэлт:

Сургуулийн цахим хэрэглээний зардлаас нягтлан бодогч 150.0 мянган төгрөгийн дата авсан нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 “батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах,” заалт, БШУС-ын 2019 оны А/170 дугаар тушаалын гуравдугаар батлагдсан “Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн цахим хэрэглээний зардлыг төлөвлөх, хуваарилах заавар”-тай нийцэхгүй, “үнэлгээ ба хуваарилалт” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

##### Өгсөн зөвлөмж:

Төсвийг батлагдсан зориулалт, арга хэмжээний дагуу, холбогдох хууль, журам, зааварт нийцүүлэн зарцуулж байх.

### **3. Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой асуудал**

#### **Илрүүлэлт:**

Цахим хэрэглээний зардлаас багш нарын 2024 оны эхний 5 сард хэрэглэх датаны зардал 2,700.0 мянган төгрөгийг урьдчилан шилжүүлсэн боловч урьдчилж төлсөн зардлаар бүртгээгүй байгаа нь Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын 4.26 “Бэлтгэн нийлүүлэгчид бараа бүтээгдэхүүн үйлчилгээний үнийг урьдчилж төлсөн төлбөр/зардал/ гэнэ. Энэ нь төлбөр хийгдсэн боловч тайлант хугацаанд гараагүй байгаа зардал учраас хөрөнгө гэж бүртгэнэ” гэсэн заалт, үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангахгүй байна.

#### **Өгсөн зөвлөмж:**

**Нягтлан бодох бүртгэлийн холбогдох стандарт журам зааврыг мөрдөж ажиллах**

### **4. Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой асуудал**

#### **Илрүүлэлт:**

Хангамжийн бараа материалын дансанд БШУЯ-аас нийлүүлсэн 2022 он болон 2023 оны 2,951.9 мянган төгрөгийн түрээсийн номын орлогыг нэр төрөл, тоо хэмжээгээр нь ангилж бүртгээгүй зөвхөн нийт дүнгээр нь бүртгэж тайлагнасан байгаа нь нь Нягтлан бодох бүртгэлийн хуулийн 20.2.3.”холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах” заалт болон үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

#### **Өгсөн зөвлөмж**

Түрээсийн номыг холбогдох баримтыг үндэслэн нэр төрөл тоо хэмжээгээр нь бүртгэх

### **5. Шилэн дансны хөтлөлттэй холбоотой асуудал**

#### **Илрүүлэлт:**

Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд мэдээлбэл зохих цалингийн зардлаас бусад орлогын 893,499.1 мянган төгрөгийн 17 мэдээлэл, зарлагын 119,016.5 мянган төгрөгийн 6 мэдээллийг дутуу мэдээлсэн нь шилэн дансны тухай хуулийн 6.4.5.”цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр;”мэдээлнэ гэсэн заалт, нийцсэн бөгөөд зохистой батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байх

#### **Өгсөн зөвлөмж**

Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг мөрдөж мэдээллийг тухай бүр байршуулж байх.

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайлан хүлээн авсан өдрөөс хойш 30 хоногийн дотор, биелэлтийг 2024 оны 9 дүгээр сарын 20-ны өдрийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье

#### 4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

##### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Урьдчилж гарсан зардлыг бүртгээгүй	1	2,700.0					1	2,700.0				
00 үлдэгдэлтэй хөрөнгийг дахин үнэлээгүй	1	0					1	0				
Түрээсийн номыг нэр төрлөөр ангилан бүртгээгүй	1	2,951.9					1	2,951.9				
Санхүүгийн тайланг хуулийн хугацаанд ирүүлээгүй	2								2	2		
цахим хэрэглээний зардлаас нягтлан бодогч 150.0 мянган төгрөгийн дата авсан	1	150.0					1	150.0				
Хуульд нийцэхгүй зардал гаргасан	1	8,000.0	1	8,000.0								
Дүн	7	13,801.9	1	8,000.0			4	5,801.9	2	2		

##### Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс			
			Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил						
Шилэн данс цахим хуудсанд мэдээллийг бүрэн мэдээлээгүй	1	1,012,515.6			1	1,012,516.6
Дүн	1	1,012,515.6			1	1,012,516.6

##### 5. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
А	1	2	3	4	5	7	8	9	10

Хөвсгөл аймгийн Цагааннуур сумын ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

1	ТШЗ	1	1			1			
2	Төсөл, хөтөлбөр								
3	ЗГТС								
4	ТТЗ								
5	ТЕЗ								
	<b>НИЙТ</b>	<b>1</b>	<b>1</b>			<b>1</b>			



## ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР АКТ

2024 оны 02 сарын 26 өдөр

№ 36/А.2270439/ХБА-2024/  
188/ХА-СМА-ТММЗ

Мөрөн сум

### Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хөвсгөл аймгийн Цагааннуур сумын ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ.  
**Үүнд:**

Багшийн тасралтгүй хөгжлийг дэмжих болон байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээний урамшууллын батлагдсан төсвийн хүрээнд зардал гаргахдаа мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх чиг үүрэгтэй, аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газрын Заах аргын нэгдлийн хэлтсийн дарга Я. Дүүрэнбилэгтэй гэрээ байгуулан, сургалт хийлгэж 8,000,000/найман сая / төгрөгийн төлбөр төлсөн.

Энэ нь Боловсролын ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.5-д "Аймаг, нийслэлийн боловсролын газар, дүүргийн боловсролын хэлтэс харьяа нутаг дэвсгэртээ дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ: өмчийн хэлбэр үл харгалзан бүх түвшний боловсролын сургалтын байгууллагад мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх, багш, ажилтны мэргэжлийн хөгжлийг хангах, зөвлөн туслах", Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.3-т "төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах" гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны 12 дугаар сарын 09-ны өдрийн А/95 дугаар тушаал "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.3.8-д "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн" гэж заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх, хамтран ажиллах чиг үүрэгтэй албан хаагчид гэрээгээр төлсөн төлбөр 8,000,000 /найман сая/ төгрөгийг Боловсрол, шинжлэх ухааны газрын заах аргын нэгдлийн хэлтсийн дарга Я. Дүүрэнбилэгээс гаргуулж Хөвсгөл аймгийн Төрийн сан дахь 100170000955/Хө.Бусад нэр заагдаагүй орлого/ тоот дансанд төвлөрүүлэх;
2. Актын биелэлтийг 2024 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн дотор Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газар<sup>1</sup>т нотлох баримтын хамт ирүүлэхийг Цагааннуур сумын ерөнхий боловсролын сургуулийн захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч Ч.Оюунбадам, нягтлан бодогч С.Отгонжаргал нарт хариуцуулав.

### ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
"ИХЭР МӨРӨН АУДИТ" ХХК  
ЗАХИРАЛ

А.ЭРДЭНЭБААТАР

Б.МЯДАГМАА

<sup>1</sup> Хөвсгөл аймаг, Мөрөн сум, 8-р баг, аймгийн ЗДТГ-ын байр, А корпус, 3 давхар, 303 тоот



## ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 09 сарын 26 өдөр

№ 22/А.2270439/ХӨА-2024/  
188/АА-СМА-ТШЗ

Мөрөн сум

### Сахилгын хариуцлага тооцуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Цагааннуур сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Цагааннуур сумын Ерөнхий боловсролын сургуулийн захирал, нягтлан бодогч нар нь 2023 оны санхүүгийн тайланг төсвийн тухай хуульд заасан цаглаварт хугацааг хоцроож 2024 оны 02 сарын 19-ны өдөр Ихэрмөрөн-аудит ХХК-д ирүүлсэн.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-т "төсвийн шууд захирагч улирлын төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг дараа улирлын эхний сарын 15-ны дотор гаргаж харьяалагдах дээд шатны төсвийн захирагчид, жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг дараа оны 01 дүгээр сарын 25-ны дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлж, аудит хийсэн санхүүгийн тайланг 02 дугаар сарын 25-ны дотор харьяалагдах дээд шатны төсвийн захирагчид хүргүүлэх" гэж заасныг зөрчсөн ба эрх үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 42 дүгээр зүйлийн 42.3-т "Энэ хуулийн 42.1, 42.2-т заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд төрийн аудитын байгууллага тухайн албан хаагчид холбогдох сахилгын шийтгэл ногдуулах, албан тушаалаас чөлөөлөх талаар эрх бүхий албан тушаалтанд албан шаардлага өгөх ба эрх бүхий албан тушаалтан ямар шийдвэр гаргасан талаараа албан шаардлагад заасан хугацаанд төрийн аудитын байгууллагад хариу мэдэгдэнэ." гэж заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Цагааннуур сумын Ерөнхий боловсролын сургуулийн захирал Ч.Оюунбадамд хуульд заасны дагуу сахилгын шийтгэл ноогдуулж биелэлтийг 2024 оны 09 дүгээр сарын 20-ны дотор Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газар<sup>1</sup>т ирүүлэхийг Хөвсгөл аймгийн Боловсрол шинжлэх ухааны газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Ш.Отгон-Эрдэнэд даалгав.

### АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

А.ЭРДЭНЭБААТАР

"ИХЭР МӨРӨН АУДИТ" ХХК  
ЗАХИРАЛ

Б.МЯДАГМАА

<sup>1</sup> Хөвсгөл аймаг, Мөрөн сум, 8 дугаар баг, аймгийн ЗДТГ-ын байр, А корпус, 3 давхар, 303 тоот



## ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 02 сарын 26 өдөр

№ 23/А2270439/ХДА-2024/  
188/НА-С/III А-III ШЗ

Мөрөн сум

### Сахилгын хариуцлага тооцуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Цагааннуур сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Цагааннуур сумын Ерөнхий боловсролын сургуулийн захирал, нягтлан бодогч нар нь 2023 оны санхүүгийн тайланг төсвийн тухай хуульд заасан цаглаварт хугацааг хоцроож 2024 оны 02 сарын 19-ны өдөр Ихэрмөрөн-аудит ХХК-д ирүүлсэн.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-т “төсвийн шууд захирагч улирлын төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг дараа улирлын эхний сарын 15-ны дотор гаргаж харьяалагдах дээд шатны төсвийн захирагчид, жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг дараа оны 01 дүгээр сарын 25-ны дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлж, аудит хийсэн санхүүгийн тайланг 02 дугаар сарын 25-ны дотор харьяалагдах дээд шатны төсвийн захирагчид хүргүүлэх” гэж заасныг зөрчсөн ба Эрх, үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 42 дүгээр зүйлийн 42.3-т “Энэ хуулийн 42.1, 42.2-т заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд төрийн аудитын байгууллага тухайн албан хаагчид холбогдох сахилгын шийтгэл ногдуулах, албан тушаалаас чөлөөлөх талаар эрх бүхий албан тушаалтанд албан шаардлага өгөх ба эрх бүхий албан тушаалтан ямар шийдвэр гаргасан талаараа албан шаардлагад заасан хугацаанд төрийн аудитын байгууллагад хариу мэдэгдэнэ.” гэсэн заалтыг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Цагааннуур сумын Ерөнхий боловсролын сургуулийн нягтлан бодогч С.Отгонжаргалд хуульд заасны дагуу сахилгын шийтгэл оногдуулж, биелэлтийг 2024 оны 09 дүгээр сарын 20-ны дотор Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газар<sup>1</sup>т ирүүлэхийг Цагааннуур сумын Ерөнхий боловсролын сургуулийн захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ч.Оюунбадамд даалгав.

### АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
“ИХЭР МӨРӨН АУДИТ” ХХК  
ЗАХИРАЛ

А.ЭРДЭНЭБААТАР

Б.МЯДАГМАА

<sup>1</sup> Хөвсгөл аймаг, Мөрөн сум, 8 дугаар баг, аймгийн ЗДТГ-ын байр, А корпус, 3 давхар, 303 тоот